



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 08 өдөр

Дугаар A/513

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.42 дахь заалт, аймгийн Засаг даргын үйл ажилалгааны хөтөлбөрийн 2.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх, үндэсний өв соёлоо дэлхийд сурталчлах, хамгийн олон хөөмийчтэйгээр Геннисийн номонд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах зардалд 3 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 3 000 000 /Гурван сая/ төгрөг Хөшөөт хөгжил сангийн төсөл, арга хэмжээний 2018 оны төсвийн тодотголоор батлагдсан 4.6 дахь заалтанд тусгагдсан зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zax-A/513-Da

02 02718



Аймгийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/513 дугаар захирамжийн хавсралт

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Нийт /төгрөг/
1	Чандмань-Ховд-Дөргөн-Эрдэнэбүрэн ирж буцах болон хот доторх орчмын зураг авалтын зардал	600 км	1920	1152000
2	Дэлхийн хөөмийн холбооны төлөөлөгчийн ажлын урамшуулал /Гэрээний дагуу/	8 сар	500000	500000
3	Албан тоот гэрээний email орчуулгын зардал	35 хуудас	100 000	650 000
4	Бусад зардал			698000
	Нийт			3 000 000